

“28 дахь удаагийн Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч гадаад иргэдийн Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”-д оролцох бүтээлийг хүлээн авах тухай

Олон нийтийн байгууллага, Японы Олон улсын сургалтын хамтын ажиллагааны байгууллага (JITCO) нь, доор дурьдсаны дагуу Япон хэлний зохион бичлэгийн уралдаанд оролцох бүтээлийг хүлээн авна. Та бүхнийг уралдаанд идэвхтэй оролцохыг урьж байна.

- 1. Уралдаанд оролцогчдод тавигдах шаардлага** Бүтээл хүлээн авах хугацаанд Японд оршин сууж буй Ур чадварын дадлагажигч, эсвэл сургалтанд хамрагдагч гадаад иргэн байх
Нэг хүн нэг бүтээлээр оролцох ба, зөвхөн өөрийн зохиосон, өмнө нь олон нийтэд дэлгэж байгаагүй бүтээл байна.
- 2. Бүтээл хүлээн авах хугацаа** 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр (Лхагва)-өөс эхлэн хүлээн авах ба цаад хугацаа нь 2020 оны 5 дугаар сарын 10-ны өдөр (Даваа)
- 3. Сэдэв** Чөлөөт сэдэв (Тодорхой сэдэв заахгүй тул, чөлөөтэй бичнэ үү.)
- 4. Зохион бичлэгийг бичих хэл** Япон хэл
- 5. Уралдаанд оролцох бүтээлд тавигдах шаардлага** А4-ийн хэмжээний, 400 үсгийн багтаамж бүхий гар бичмэлийн зориулалтын цаас 3 хуудас, үсгийн тоо нь 1,200 хүртэл (Зохион бичлэг нь) байна.
▼Зөвхөн уралдаанд оролцогчийн өөрийн гараар бичсэн эх хувь байна. Ворд процессор, компьютер ашиглаж бичсэн зохион бичлэг болон эх хувийг хувилсан зохион бичлэгийг хүлээж авахгүй.
▼Бүтээлдээ зохион бичлэгийнхээ сэдэв болон овог нэрээ заавал бичсэн байна. (Гар бичмэлийн зориулалтын цаасны хүрээний гадна талд)
▼Зохион бичлэгийг босоо бичиг болон хөндлөн бичгийн алианаар нь ч бичиж болно.
▼Хэрэглэх бичгийн хэрэгслийг тусгайлан заахгүй ба, гагцхүү **харандаагаар бичих тохиолдолд, 2В-гээс дээш тод гардаг харандаа хэрэглэж бичих.**
▼Гар бичмэлийн зориулалтын цаасыг JITCO-гийн цахим хуудас (<https://www.jitco.or.jp/>)-наас гадна JITCO-гийн Япон хэлний сурах бичгийн хироба (талбай) (<https://hiroba.jitco.or.jp/>)-гаас мөн татаж авах боломжтой.
- 6. Уралдаанд оролцох арга** Уралдаанд оролцох хүсэлт гаргах хуудсанд шаардагдах зүйлсийг бөглөж, уралдаанд оролцох бүтээлдээ хавсарган, дараах хаяг руу шуудангаар ирүүлнэ үү.

<Бүтээл хүлээж авах хаяг>
Токио 108-0023, Минато-кү, Шибаура 2-11-5, Игараши билдинг 11-р давхар
Олон нийтийн байгууллага, Японы Олон улсын сургалтын хамтын ажиллагааны байгууллага, Япон хэлний зохион бичлэгийн уралдааны хэрэг эрхлэх алба

- ▼Уралдаанд оролцох хүсэлт гаргах хуудсыг уг товхимлын 37-р хуудсанд оруулсан байгаа бөгөөд, уг хуудсыг хувилж хэрэглэнэ үү.
 - Уг хуудсыг, JITCO-гийн цахим хуудас болон JITCO-гийн Япон хэлний сурах бичгийн хироба (талбай)-гаас мөн татаж авах боломжтой.
 - ▼Уралдаанд оролцох хүсэлт гаргах хуудсыг уралдаанд оролцох хүн өөрөө бөглөж болох ба, бүрэн гүйцэд бөглөнө үү.
 - ▼FAX болон E-mail-ээр хүлээж авахгүй.
- 7. Уралдааны шагнал** Шилдгийн шилдэг бүтээлийн шагнал (Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч нийт 4 орчим хүн) ... Шагналын гэрчилгээ болон Шагналын дагалдах мөнгө (50,000 иен)
Шилдэг бүтээлийн шагнал (Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч нийт 4 орчим хүн) ... Шагналын гэрчилгээ болон Шагналын дагалдах мөнгө (30,000 иен)
Онцгой сайн бүтээлийн шагнал (Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч нийт 20 орчим хүн) ... Шагналын гэрчилгээ болон Шагналын дагалдах мөнгө (20,000 иен)
Сайн бүтээлийн шагнал (Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч нийт 20 орчим хүн) ... Шагналын дагалдах мөнгө (10,000 иен)
▼Дээрх шагналт байранд шалгарсан бүтээл болон Сайн бүтээлийн шагнал гардсан бүтээлийг “Япон хэлний зохион бичлэгийн уралдааны Шилдэг бүтээлийн цомог”-т оруулна.
 - 8. Шагналт байранд шалгарсан бүтээлийг зарлах тухай** Шагналт байранд шалгарсан оролцогчид тухайн оролцогчийн харъяалагдах байгууллагаар нь дамжуулан мэдэгдэхийн зэрэгцээ, 2020 оны 8 дугаар сарын сүүлчээр JITCO-гийн цахим хуудсаар дамжуулан зарлахаар төлөвлөж байна.
 - 9. Бусад**
 - (1) Сонгон шалгаруулалттай холбогдох аливаа асуултанд хариулах боломжгүй.
 - (2) Уралдааны тавигдах шаардлагыг хангаагүй бүтээлийг сонгон шалгаруулалтанд оруулахгүй.
 - (3) Уралдаанд оролцох хүсэлт гаргах хуудсанд бичигдсэн хувь хүний мэдээллийг зөвхөн тус уралдааныг зохион байгуулахад шаардагдах хүрээнд хэрэглэнэ.
 - (4) Ирүүлсэн бүтээлийг буцааж өгөхгүй.
 - (5) Ирүүлсэн бүтээлийн зохиогчийн эрх нь JITCO-д байна.
 - 10. Лавлах газар** Олон нийтийн байгууллага, Японы Олон улсын сургалтын хамтын ажиллагааны байгууллага, Япон хэлний зохион бичлэгийн уралдааны хэрэг эрхлэх алба
Утас: 03-4306-1184 / FAX:03-4306-1119

(Анхааруулга) Хувилсан (Хуулбар) бүтээлийг сонгон шалгаруулалтанд оруулахгүй тул, заавал уралдаанд оролцогчийн өөрийн гараар бичсэн эх хувийг ирүүлнэ үү.

Уралдаанд оролцсон бүх хүнд, уралдаанд оролцсон бүх хүний нэрсийн жагсаалт (Овог нэр, харъяалагдах байгууллагын нэр)-ыг төгсгөлд нь нийтэлсэн “Шилдэг бүтээлийн цомог” нэг нэгийг бэлэглэнэ.